



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧ Д.РЭГДЭЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23. № 3/352.
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинжлэх ухааны академийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Шинжлэх ухааны академийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шинжлэх ухааны академийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл
авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу**

ҮАГ-ын Санхүүгийн
аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас 261663

Аудитын менежер
Я.Самбууням
Утас 260512

Монгол Улсын Үндэсний
аудитын газар

Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46 Бага
тойруу 6

Цахим хаяг [www. audit.mn](http://www.audit.mn)

Ниямазон аудит ХХК
Захирал З.Цээнээ
Ахлах аудитор Ж.Батнасан

Аудитын тайлан

Хавсралт 1 Аудитын гэрчилгээ

Хавсралт 2 Менежментийн захидал

Хавсралт 3 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4 Аудит хийгдсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналтын талаар
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Аудитын гэрчилгээний талаар санал дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 18.5, Төсвийн тухай хуулийн 30.1.1 болон 8.9.1 дэх заалт, МУ-ын Ерөнхий аудиторын 2016 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн А/98 дугаар тушаалыг үндэслэн Шинжлэх ухааны академи /ШУА/-ийн Тэргүүлэгчдийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/52/СТА-ШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 1 дүгээр сарын 25-наас 2016 оны 2 дугаар сарын 23-ны хооронд хийхээр төлөвлөн Ниямазон аудит ХХК-ийн аудиторууд хэрэгжүүлэв.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Ниямазон аудит ХХК-д 1/43 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 24-нд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар нь Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхдээ Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн эх үүсвэрийн ангилал, Төсвийн

бусад мэдээллийн болон балансын дансны ангилал, 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 2016 оны 7 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

ШУА нь нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зорилтыг шийдвэрлэхэд гол хүчин зүйл болохуйц чадавхи бүхий олон улсын түвшинд ойртсон онолын суурь судалгааны хүрээлэнгүүдийн сүлжээ бүхий Монгол Улсын шинжлэх ухааны төв байгууллага болох зорилготой.

ШУА-ийн харъяанд Анагаах ухааны академи, Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академи болон Физик технологийн, Хэл уран зохиолын, Философийн зэрэг 10 хүрээлэн үйл ажиллагаа явуулж байна. ШУА-ийн удирдах дээд байгууллага нь академийн бүх гишүүдийн Их чуулган бөгөөд Их чуулганы чөлөөт цагт өдөр тутмын үйл ажиллагааг ШУА-ийн тэргүүлэгчид удирдана.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна гэж заасны дагуу ШУА-ын ерөнхийлөгч төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Аудитын явцад төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 6 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Аудитын нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэх явцад гарсан зарим онцлог ажил гүйлгээнээс дурдвал дараах байдалтай байна.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар нь ШУА-ийн ерөнхийлөгчийн 2016 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/76 дугаар тушаалаар батлагдсан хууль тогтоомж, журам болон УСНББОУС-д нийцүүлсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага ” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн тооцоолохын "Acolous" програм ашиглан санхүүгийн тайланг боловсруулж гаргасан байна.

Тав. Материаллаг байдлын түвшин

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангаар гарсан нийт зардлын дүнгээс 2 хувиар буюу 11.4 сая төгрөгөөр урьдчилан тооцсон бөгөөд гүйцэтгэлийн шатанд жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн үйл ажиллагааны нийт зардал буюу 1,401.5 сая төгрөгөөс 2 хувиар тооцоход 28.0 сая төгрөг байна.

Зургаа. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар 2016 онд нийт 1,298.4 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй, гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал төсвийн санхүүжилтэд 1,283.4 сая төгрөг хүлээн авч, урсгал зардалд 1,287.3 сая төгрөгийг тус тус зарцуулж, 83.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Найм. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан байна.

Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, үйл ажиллагааны орлого, цалин хөлс зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 6 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 80 хувь, мөнгөн хөрөнгийн 100 хувь, бараа материалын 50 хувь, авлага өглөгийн 100 хувийг тус тус эзэлж байна.

Арав. Гол, онцлог гүйлгээний талаар

Тус газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, гадаад томилолт, авлага, өглөг шатахууны зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Тус байгууллага нь он дамжсан авлага, өглөгийн үлдэгдэлтэй байсан ба 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд авлага 8.9 сая төгрөгийн, урьдчилж төлсөн төлбөр 62.4 сая төгрөгийн, өглөг 3.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан ба үүний 30 хувьд тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4-т "бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Авлага, өглөгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Дансны нэр	2014 он	2015 он	2016 он
Авлага	38.5	14.3	8.9
Урьдчилгаа	68.7	61.4	62.4
Өглөг	67.7	6.9	3.9

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж болгов.

2. ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар нь Соёмбо принтинг ХХК-тай "Тогтвортой хөгжил мэдлэг" номын монгол орчуулга 1650 ширхэг номыг хэвлүүлэхээр 2012 оны 8 дугаар сард байгуулсан гэрээний дагуу 39.9 сая төгрөгийг

шилжүүлэн урьдчилж төлсөн төлбөр дансанд бүртгэжээ. Гэтэл төлбөр хийгдснээс хойш 4 жилийн хугацаа өнгөрсөн боловч тус компаниас 2016 онд 11.6 сая төгрөгийн ном орлогодож авсан ба оны эцсийн байдлаар 28.3 сая төгрөгийн авлагатай байна.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар нь Соёмбо принтинг ХХК гэрээний үүргээ зөрчсөн атал тайлант онд 17.8 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлж төлбөр хийсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Соёмбо принтинг ХХК-тай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хангуулах талаар албан шаардлага өгөв.

3. ШУА-ийн ерөнхийлөгч 2016 оны 2 дугаар сард Япон улсад Зүүн хойд ази судлалын олон улсын хуралд , 6 дугаар сард Варшавт Торгоны зам 2016 форумд, БНХАУ-д Торгоны зам "Think tank" зөвлөлдөх уулзалтанд тус тус дээд шатны төсвийн захирагчийн бус ШУА-ийн дэд ерөнхийлөгчийн тушаалаар оролцож, нийт 1,9 сая төгрөгийн зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь ... дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө, төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", 16 дугаар зүйлийн 16.5-д заасан төсвийн шууд захирагчийн эрхийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж болгов.

Арван хоёр. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар санхүүгийн тайланд 24.5 сая төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Арван тав. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 24.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба дээр дурдсан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 3 зөвлөмж өгсөн болно.

Арван зургаа. Зөрчилгүй санал дүгнэлт

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль , УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлсэн байна.



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас 261663

Аудитын менежер
Я.Самбууням
Утас 261885

Монгол Улсын Үндэсний
Аудитын газар

Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-
3 Засгийн газрын IY байр
Улаанбаатар хот 15160 Монгол
Улс

Цахим хуудас www.audit.mn

Ниямазон аудит ХХК
Захирал З.Цээнээ
Ахлах аудитор Ж.Батнасан

Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд
Амарын гудамж, Соёлын төв өргөө

Менежментийн захидал

Асуудал 1

Авлага, өглөгийн талаар

Асуудал 2

Гадаад томилолтын талаар

Менежментийн захидал

Бид аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах явдал бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга А.Баярбаатар, нягтлан бодогч Х.Гантуяа болон санхүүгийн бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага нь он дамжсан авлага, өглөгийн үлдэгдэлтэй байсан ба 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд авлага 8.9 сая төгрөгийн, урьдчилж төлсөн төлбөр 62.4 сая төгрөгийн, өглөг 3.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан ба үүний 30 хувьд тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4-т "бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдлүүд

Тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс найдваргүй авлага үүсэх, төсвийн хөрөнгө үрэгдэх

бөбөб

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах

Авлага, өглөгийн тооцоог харилцагчтай бүрэн нийлж байх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

ШУА-ийн ерөнхийлөгч 2016 оны 2 дугаар сард Япон улсад Зүүн хойд ази судлалын олон улсын хуралд, 6 дугаар сард Варшавт Торгоны зам 2016 форумд, БНХАУ-д Торгоны зам "Think tank" зөвлөлдөх уулзалтанд тус тус дээд шатны төсвийн захирагчийн бус ШУА-ийн дэд ерөнхийлөгчийн тушаалаар оролцож, нийт 1,9 сая төгрөгийн зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь ... дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө, төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", 16 дугаар зүйлийн 16.5-д заасан төсвийн шууд захирагчийн эрхийг зөрчсөн байна.

Эрсдлүүд

Төсвийн хууль зөрчигдөх, гадаад томилолтын зардал хэтрэх

ҮАГ-ын зөвлөмж

ШУА-ийн ерөнхийлөгч нь гадаадад томилолтоор ажиллахдаа дээд шатны төсөв захирагчийн шийдвэр гаргуулдаг байх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ГАЗРЫН
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>115,724,162.69</u>	<u>158,813,448.54</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,593,536	2,951,953
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	5,593,536	2,951,953
31110	Төгрөг	5,593,536	2,951,953
33	АВЛАГА	14,326,173.90	8,943,567.78
335	Бусад авлага	14,326,173.90	8,943,567.78
3351	Байгууллагаас авах авлага	14,326,173.90	8,943,567.78
34	УРЬДЧИЛГАА	61,357,450.00	62,433,054.00
34600	Урьдчилж гарсан зардал	53,978,400.00	58,460,700.00
3471	Урьдчилгаа тооцоо	7,379,050.00	3,972,354.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	7,379,050.00	3,972,354.00
35	БАРАА МАТЕРИАЛ	34,447,002.79	84,484,873.76
354	Хангамжийн материал	34,447,002.79	84,484,873.76
35410	Бичиг хэргийн материал		2,161,580.00
35420	Аж ахуйн материал	34,447,002.79	80,583,293.76
35430	Сэлбэг хэрэгсэл		480,000.00
35440	Түлш, шатах тослох материал		180,000.00
35450	Барилгын засварын материал		1,080,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>78,655,964.96</u>	<u>62,361,008.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	78,655,964.96	62,361,008.15
392	Биет хөрөнгө	78,155,964.96	61,304,758.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	100,562,308	100,562,308.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(75,813,738)	(92,289,389.63)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	37,452,900	37,452,900.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,755,819.93)	(22,479,359.93)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	100,503,858.95	118,758,648.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	(79,650,731.72)	(95,981,046.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,344,165	56,316,765.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,711,093.67)	(42,260,184.39)
39217	Ном	1,224,116.60	1,224,116.60
393	Биет бус хөрөнгө	500,000	1,056,250.03
39301	Програм хангамж	1,500,000	2,800,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,000,000)	(1,743,749.97)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>194,380,127.65</u>	<u>221,174,456.69</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,902,262.03</u>	<u>3,925,813.85</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,902,262.03	3,925,813.85
413	Өглөг	6,902,262.03	3,925,813.85
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	163,834.51	316,186.33
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		279,200.00
4136	Бусад өглөг	6,738,427.52	3,330,427.52
41361	Байгууллагад төлөх өглөг	6,210,427.52	3,330,427.52
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	528,000	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>187,477,865.62</u>	<u>217,248,642.84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	187,477,865.62	217,248,642.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	141,443,666.75	141,443,666.75
51101	Өмч: - төрийн	141,443,666.75	141,443,666.75
512	Хуримтлагдсан үр дүн	42389110.61	72159887.83
51210	Өмнөх үеийн үр дүн	42,389,110.61	42,389,110.61
51220	Тайлант үеийн үр дүн		29,770,777.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,645,088.26	3,645,088.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>194,380,127.65</u>	<u>221,174,456.69</u>

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ГАЗРЫН
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,354,718,345.60	1,431,301,700
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1,633,500
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	1,633,500
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	1,633,500
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		1,633,500
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,354,718,345.60	1,429,668,200
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,238,941,420.00	1,366,939,200
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,238,941,420.00	1,366,939,200
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	115,776,925.60	62,729,000
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	981,948.96	9,945,000
131102	Төсвийн жилийн явцад уйх-аас соёрхон баталсан, эг хөрөнгө, хөрөнгө, бусад, ОУ байгууллагаас авсан		39,984,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,800,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хэрэгсэл бий болсон нэмэлт орлого	114,794,976.64	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,388,711,449.15	1,401,530,922.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,388,711,449.15	1,401,530,922.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,311,570,617.31	1,287,850,140.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	883,716,285.57	866,926,004.71
210101	Үндсэн цалин	883,716,285.57	866,926,004.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,939,414.01	85,966,156
210201	Тэтгэврийн даатгал	61,423,590.80	60,735,974
210202	Тэтгэмжийн даатгал	7,012,338.82	6,933,838
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,765,423.01	8,667,297
210204	Ажилгүйдлийн даатгал	748,462.79	740,084
210205	Эрүүл мэндийн даатгал	8,989,598.59	8,888,963
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,034,000.00	32,034,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,613,939.74	44,287,749.02
210401	Бичиг хэрэг	3,005,141	3,680,130.00
210402	Тээвэр, шатахуун	3,110,000	2,855,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,471,948.97	3,370,602.99
210404	Ном, хэвлэл	7,280,200	29,493,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,746,650	4,889,016.03
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,689,650.00	13,579,696
210601	Багаж, техник, хэрэгсэл		433,200
210602	Тавилга		13,146,496
210604	Урсгал засвар	8,689,650.00	
2107	Томилолт, зочны зардал	88,255,403.00	6,409,260.00
210701	Гадаад албан томилолт	43,606,005.00	
210702	Дотоод албан томилолт	20,910,870.00	6,409,260.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	23,738,528.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,207,915.00	128,109,218.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,952,240.00	121,737,018.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		4,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,044,675	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,000	128,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	184,114,009.99	110,538,056.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,643,700.00	1,079,075.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	111,608,301.00	68,636,635.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,862,008.99	40,822,346.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,140,831.84	113,680,782.24
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,429,042.00	4,708,714
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,429,042.00	4,708,714
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,828,180.00	25,416,091.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,828,180.00	24,169,603.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		1,246,488.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	68,883,609.84	83,555,977.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	68,883,609.84	83,555,977.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(33,993,103.55)	29,770,777.22
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(33,993,103.55)	29,770,777.22

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ГАЗРЫН
АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	141,443,666.75	3,645,088.26	76,347,214.16	221,435,969.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			35,000.00	35,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	141,443,666.75	3,645,088.26	76,382,214.16	221,470,969.17
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-33,993,103.55	-33,993,103.55
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	141,443,666.75	3,645,088.26	8,396,007.06	153,484,762.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	141,443,666.75	3,645,088.26	42,389,110.61	187,477,865.62
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			29,770,777.22	29,770,777.22
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	141,443,666.75	3,645,088.26	72,159,887.83	217,248,642.84

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ГАЗРЫН
АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,388,658,345.60	1,455,478,001.16
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,388,658,345.60	1,441,736,336.16
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,238,941,420.00	1,366,939,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,238,941,420.00	1,366,939,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	149,716,925.60	74,712,992
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	33,940,000.00	9,945,000
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, эг хөрөнгийн гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	114,685,998.16	39,984,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,090,927.44	
131106	Төсвийн урамшуулал		11,983,992.16
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	84,144.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		84,144.00
1402	Бараа, үйлчилгээний орлого		13,741,665.00
1.4E+07	Үндсэн бус үйл ажиллаган орлого		13,741,665.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,423,824,609.60	1,435,225,694.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,423,824,609.60	1,435,225,694.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,333,049,057.64	1,321,544,911.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	880,773,507.07	867,924,330.69
210101	Үндсэн цалин	880,773,507.07	853,866,643.69
210105	Гэрээт ажлын хөлс		14,057,687.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,642,633.70	85,907,321.14
210201	Тэтгэврийн даатгал	60,941,685.38	60,424,489.81
210202	Тэтгэмжийн даатгал	7,841,255.23	7,774,708.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,838,415.07	8,763,405.84
210204	Ажилгүйдлийн даатгал	820,116.99	813,156.88
210205	Эрүүл мэндийн даатгал	8,201,161.03	8,131,560.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,034,000	32,755,000
210304	Байрны түрээс	32,034,000	32,755,000
2104	Хангамж, бараа материалын зардал	33,361,925.39	54,067,481.99
210401	Бичиг хэрэг	3,589,850.00	5,070,710.00
210402	Тээвэр, шатахуун	3,128,000.00	3,010,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,930,575.39	3,351,002.99
210404	Ном, хэвлэл	18,977,700.00	36,770,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,735,800.00	5,864,969.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,227,590.00	15,216,396.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,088,200.00
210604	Урсгал засвар	11,227,590.00	14,128,196.00
2107	Томилолт, зочны зардал	129,904,355.48	10,466,440.00
210701	Гадаад албан томилолт	81,878,047.48	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	24,036,370.00	7,466,440.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	23,989,938.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,851,065.00	168,656,954.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,595,390.00	162,284,754.10
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	4,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,044,675.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,000.00	128,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	149,253,981.00	86,550,988.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,740,000.00	11,871,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	111,513,981.00	74,679,088.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,775,552	113,680,782.24
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,429,042	4,708,714
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,429,042	4,708,714
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,838,590.00	25,416,091.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,838,590.00	24,169,603.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		1,246,488.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	82,507,919.96	83,555,977.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	82,507,919.96	83,555,977.24
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(35,166,264.00)</u>	<u>20,252,307.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,746,000.00	22,893,890.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,746,000.00	22,893,890.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,746,000.00	22,893,890.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,746,000.00	22,893,890.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,746,000.00)</u>	<u>(22,893,890.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(37,912,264.00)	(2,641,583.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	43,505,800.00	5,593,536.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,593,536.00	2,951,953.00

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ГАЗРЫН
АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,371,935,800	1,287,329,505.92	84,606,294.08	93.8%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,371,935,800	1,287,329,505.92	84,606,294.08	93.8%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,346,515,800	1,257,204,700.92	89,311,099.08	93.4%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	927,348,600	867,840,186.69	59,508,413.31	93.6%
210101	Үндсэн цалин	908,148,600	853,782,499.69	54,366,100.31	94.0%
210105	Гэрээт ажлын хөлс	19,200,000	14,057,687.00	5,142,313.00	73.2%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,213,700	85,907,321.14	16,306,378.86	84.0%
210201	Тэтгэврийн даатгал	70,890,900	85,907,321.14	(15,016,421.14)	121.2%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,755,000	32,755,000.00	-	100.0%
210304	Байрны түрээс	32,755,000	32,755,000.00	-	100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	53,782,700	53,725,850.99	56,849.01	99.9%
210401	Бичиг хэрэг	5,075,200	5,070,710.00	4,490.00	99.9%
210402	Тээвэр, шатахуун	2,997,800	3,010,000.00	(12,200.00)	100.4%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,623,800	3,351,002.99	272,797.01	92.5%
210404	Ном, хэвлэл	37,069,800	36,770,800.00	299,000.00	99.2%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,016,100	5,523,338.00	(507,238.00)	110.1%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,174,000	33,733,386.00	3,440,614.00	90.7%
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,400,000	19,605,190.00	794,810.00	96.1%
210604	Урсгал засвар	16,774,000	14,128,196.00	2,645,804.00	84.2%
2107	Томилолт, зочны зардал	14,431,800	7,466,440.00	6,965,360.00	51.7%
210702	Дотоод албан томилолт	14,431,800	7,466,440.00	6,965,360.00	51.7%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	130,430,000	129,972,954.10	457,045.90	100%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,930,000	123,600,754.10	329,245.90	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,200,000	4,200,000.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	2,000,000	2,000,000.00	-	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	166,700	128,200.00	38,500.00	77%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	133,300	44,000.00	89,300.00	33%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,380,000	45,803,562.00	2,576,438.00	95%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,900,000	5,512,135.00	387,865.00	93%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,480,000	40,291,427.00	2,188,573.00	95%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,420,000	30,124,805.00	(4,704,805.00)	119%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	4,708,714.00	(4,708,714.00)	
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		4,708,714.00	(4,708,714.00)	
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,420,000	25,416,091.00	3,909.00	100%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,170,000	24,169,603.00	397.00	100%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,250,000	1,246,488.00	3,512.00	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,298,439,800	1,287,688,222.92	10,751,577.08	99%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,298,439,800	1,283,383,222.92	15,056,577.08	99%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,298,439,800	1,283,383,222.92	15,056,577.08	99%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	4,305,000.00	(4,305,000.00)	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,305,000.00	(4,305,000.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5,593,536.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,951,953.00		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	82.00	82.00		100%
620001	Удирдах ажилтан	58.00	58.00		100%
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00		100%
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00		100%